

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 1 дүүгэр
сарын 29-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хорооны орон тооны бус гишүүнд урамшуулал
олгох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 17.2, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар шинэчилэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны “Хорооны орон тооны бус гишүүдэд олгох урамшуулал, түүнийг олгох журам” батлах тухай 20 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

**ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД
УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны орон тооны бус гишүүнд урамшуулал олгох, урамшууллын хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.

**Хоёр. Орон тооны гишүүнд урамшуулал олгох,
урамшууллын хэмжээг тогтоох**

2.1. Хорооны орон тооны бус гишүүнд олгох урамшууллын хэмжээг Хорооны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.2. Хорооны хуралдаан хариуцсан мэргэжилтэн нь хуралдааны ирцийн бүртгэлийг хөтөлж, Хорооны Ажлын алба баталгаажуулсны дараа Санхүү, аж ахуйн тасагт гаргаж өгнө.

2.3. Хорооны дарга өөрөөр тогтоогоогүй бол Санхүү, аж ахуйн тасаг нь хуралдааны ирцийн бүртгэлийг үндэслэн орон тооны бус гишүүдэд сард олговол зохих урамшууллын хэмжээнээс хувь тэнцүүлэн тооцсон дүнтэй тэнцэх урамшууллын мөнгийг Хорооны төсвийн холбогдох зардлаас гишүүдийн цалингийн картанд шилжүүлнэ;

2.4. Урамшууллын мөнгийг хүлээн авсны дараа орон тооны бус гишүүд цалингийн цэсд гарын үсгээ зурж баримтжуулна.

2.5. Хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа хууль тогтоомжоор тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд дуусгавар болсон уг хугацаанаас эхлэн тухайн гишүүнд олгох урамшууллыг зогсооно.